



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/191

Булган сум

Сургалтын зардалд хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэн ажиллах “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хотын захиргаа болон Бусан хотын Онцгой байдлын газраас 2025 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд тус хотод зохион байгуулах “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа ба эрт зарлан мэдээлэх систем” сэдэвт сургалтад Онцгой байдлын газрын Ахлах байцаагч, хошууч Х.Чинзоригийг оролцуулсугай.

2.Сургалтын зардалд шаардагдах 5,650,000 (таван сая зургаан зуун тавин мянга) төгрөгийг гамшгийн эрсдлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010292